



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ДОА-2022/164/НА/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Чойбалсан хот

2022 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Аудитор: Ч.Удвалноров

Утас: 7058-4207, Цахим хаяг: udvalnorovch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

|  |    |
|--|----|
| 1. Аудитын санал дүгнэлт .....   | 3  |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....                 | 4  |
| 3. Аудитын тайлан .....  | 10 |
| 3.1 Ерөнхий зүйл .....   | 10 |
| 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....                       | 10 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....                            | 11 |
| 3.4 Материаллаг байдал .....   | 11 |
| 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....                                  | 11 |
| 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....                       | 12 |
| 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....                  | 12 |
| 3.8 Аудитын гол асуудал .....  | 12 |
| 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... | 12 |
| 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....                                      | 13 |
| 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....                              | 13 |
| 4. Аудитын илрүүлэлт.....  | 13 |
| 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....                          | 14 |

**Товчилсон үгийн жагсаалт**

|        |  |
|--------|--|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт    |
| ДОА    | Дорнод аймаг                                     |
| ЗГНХ   | Засгийн газрын нөөц хөрөнгө                      |
| ЗДНХ   | Засаг даргын нөөц хөрөнгө                        |
| НА     | Нотлох аудит                                     |
| СТА    | Санхүүгийн тайлангийн аудит                      |
| ТШЗ    | Төсвийн шууд захирагч                            |
| ҮОМШӨ  | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин |



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг  
З/ТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2022.02.23 № 118  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ДОРНОД АЙМГИЙН ТАТВАРЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА  
С.БЯМБАРАГЧАА ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Татварын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Татварын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ

011020886

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын зүйл   | Эхний үлдэгдэл        | Эцсийн үлдэгдэл       |
|------------|---|-----------------------|-----------------------|
| 1          | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>  | <b>48,318,222.00</b>  | <b>36,481,084.22</b>  |
| 33         | <b>АВЛАГА</b>   | <b>3,182,982.00</b>   | <b>5,100,000.00</b>   |
| 335        | Бусад авлага  | 3,182,982.00          | 5,100,000.00          |
| 3351       | Байгууллагаас авах авлага   | 3,182,982.00          | 5,100,000.00          |
| 35         | <b>БАРАА МАТЕРИАЛ</b>   | <b>45,135,240.00</b>  | <b>31,381,084.22</b>  |
| 354        | <b>Хангамжийн материал</b>  | <b>43,205,240.00</b>  | <b>29,761,084.22</b>  |
| 35410      | Бичиг хэргийн материал  | 6,172,211.22          | 7,043,281.22          |
| 35420      | Аж ахуйн материал   | 36,392,628.78         | 19,898,772.44         |
| 35430      | Сэлбэг хэрэгсэл   | 133,000.00            | 0.00                  |
| 35440      | Түлш, шатах тослох материал   | 507,400.00            | 2,819,030.56          |
| 35600      | Мал амьтад  | 1,930,000.00          | 1,620,000.00          |
| 2          | <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>                                    | <b>583,570,134.33</b> | <b>533,812,122.61</b> |
| 39         | <b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>   | <b>583,570,134.33</b> | <b>533,812,122.61</b> |
| 392        | <b>Биет хөрөнгө</b>   | <b>529,745,134.33</b> | <b>479,987,122.61</b> |
| 39201      | Барилга, байгууламж, орон сууц  | 230,345,593.11        | 230,345,593.11        |
| 39202      | Хуримтлагдсан элэгдэл   | -13,800,299.50        | -21,100,833.17        |
| 39203      | Авто-тээврийн хэрэгсэл  | 116,350,000.00        | 116,350,000.00        |
| 39204      | Хуримтлагдсан элэгдэл   | -34,931,398.12        | -45,338,884.23        |
| 39205      | Машин тоног төхөөрөмж(компьютер)                                      | 271,984,521.91        | 307,044,803.26        |
| 39206      | Хуримтлагдсан элэгдэл   | -82,609,409.92        | -142,439,721.45       |
| 39207      | Тавилга, аж ахуйн эд хогшил   | 75,095,349.28         | 75,095,349.28         |
| 39208      | Хуримтлагдсан элэгдэл   | -37,840,910.40        | -44,458,614.65        |
| 39214      | Бусад үндсэн хөрөнгө  | 6,476,520.66          | 6,476,520.66          |
| 39215      | Хуримтлагдсан элэгдэл   | -1,324,832.69         | -1,987,090.20         |
| 393        | <b>Биет бус хөрөнгө</b>   | <b>53,825,000.00</b>  | <b>53,825,000.00</b>  |
| 39303      | Бусад биет бус хөрөнгө  | 53,825,000.00         | 53,825,000.00         |
| 3          | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>                                    | <b>631,888,356.33</b> | <b>570,293,206.83</b> |
| 4          | <b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>   | <b>3,444,132.00</b>   | <b>0.00</b>           |
| 41         | <b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>                                      | <b>3,444,132.00</b>   | <b>0.00</b>           |
| 413        | <b>Өглөг</b>  | <b>3,444,132.00</b>   | <b>0.00</b>           |
| 41310      | Ажилчидтай холбогдсон өглөг   | 3,155,732.00          | 0.00                  |
| 4136       | Бусад өглөг   | 288,400.00            | 0.00                  |
| 41363      | Татварын өглөг /ТӨҮГ/   | 288,400.00            | 0.00                  |
| 5          | <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                                       | <b>628,444,224.33</b> | <b>570,293,206.83</b> |
| 51         | <b>Засгийн газрын хувь оролцоо</b>                                    | <b>628,444,224.33</b> | <b>570,293,206.83</b> |
| 511        | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 351,819,591.65        | 351,819,591.65        |
| 51101      | Өмч: - төрийн   | 351,819,591.65        | 351,819,591.65        |
| 512        | <b>Хуримтлагдсан үр дүн</b>   | <b>115,112,270.30</b> | <b>56,961,252.80</b>  |
| 51210      | Өмнөх үеийн үр дүн  | -27,346,065.64        | 115,112,270.30        |
| 51220      | Тайлант үеийн үр дүн  | 142,458,335.94        | -58,151,017.50        |
| 51300      | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                                      | 161,512,362.38        | 161,512,362.38        |
| 6          | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>                    | <b>631,888,356.33</b> | <b>570,293,206.83</b> |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Балансын зүйл                          | Өмнөх он                | Тайлант он              |
|------------|--|-------------------------|-------------------------|
| 1          | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b> | <b>1,013,260,494.84</b> | <b>1,031,489,876.35</b> |
| 12         | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>             | <b>186,050,044.84</b>   | <b>52,992,501.35</b>    |
| 120        | <b>Нийтлэг татварын бус орлого</b>     | <b>186,050,044.84</b>   | <b>52,992,501.35</b>    |
| 120004     | Төсөвт байгууллагын өөрийн орлого      | 186,050,044.84          | 52,992,501.35           |
| 1200045    | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого      | 186,050,044.84          | 52,992,501.35           |

|        |   |                       |                         |
|--------|---|-----------------------|-------------------------|
| 13     | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>  | <b>827,210,450.00</b> | <b>978,497,375.00</b>   |
| 1310   | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>  | <b>811,885,725.00</b> | <b>957,497,400.00</b>   |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт   | 811,885,725.00        | 957,497,400.00          |
| 1311   | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>  | <b>15,324,725.00</b>  | <b>20,999,975.00</b>    |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 13,464,725.00         | 20,999,975.00           |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө  | 1,500,000.00          | 0.00                    |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                                | 360,000.00            | 0.00                    |
| 2      | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>  | <b>870,802,141.26</b> | <b>1,089,640,893.85</b> |
| 21     | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>  | <b>870,802,141.26</b> | <b>1,089,640,893.85</b> |
| 210    | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>  | <b>848,065,432.09</b> | <b>978,797,943.24</b>   |
| 2101   | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>  | <b>606,964,028.95</b> | <b>656,165,057.67</b>   |
| 210101 | Үндсэн цалин  | 422,179,950.53        | 371,392,983.67          |
| 210102 | Нэмэгдэл  | 102,273,479.77        | 159,711,386.37          |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт   | 24,796,795.65         | 52,943,021.00           |
| 210104 | Урамшуулал  | 57,713,803.00         | 72,117,666.63           |
| 2102   | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>   | <b>88,349,818.88</b>  | <b>87,487,552.72</b>    |
| 210201 | Тэтгэврийн даатгал  | 58,977,241.45         | 61,539,862.41           |
| 210202 | Тэтгэмжийн даатгал  | 10,093,686.54         | 6,832,925.87            |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал   | 5,138,530.89          | 5,230,679.07            |
| 210204 | Ажилгүйдлын даатгал   | 1,284,632.73          | 1,264,896.92            |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал   | 12,855,727.27         | 12,619,188.45           |
| 2103   | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>  | <b>12,520,001.00</b>  | <b>12,327,200.00</b>    |
| 210301 | Гэрэл цахилгаан   | 4,469,783.87          | 4,652,600.00            |
| 210302 | Түлш, халаалт   | 5,000,004.13          | 5,248,000.00            |
| 210303 | Цэвэр, бохир ус   | 3,050,213.00          | 2,426,600.00            |
| 2104   | <b>Хангамж, бараа материалын зардал</b>   | <b>21,405,116.30</b>  | <b>44,903,644.78</b>    |
| 210401 | Бичиг хэрэг   | 6,165,613.80          | 4,640,500.00            |
| 210402 | Тээвэр, шатахуун  | 4,622,007.50          | 5,530,369.44            |
| 210403 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр   | 4,996,068.00          | 5,207,000.00            |
| 210404 | Ном, хэвлэл   | 433,600.00            | 107,600.00              |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал   | 949,333.00            | 708,950.00              |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс   | 3,828,994.00          | 28,709,225.34           |
| 210408 | Бараа материал акталсны зардал  | 409,500.00            | 0.00                    |
| 2106   | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>  | <b>3,007,911.50</b>   | <b>1,923,000.00</b>     |
| 210604 | Урсгал засвар   | 3,007,911.50          | 1,923,000.00            |
| 2107   | <b>Томилолт, зочны зардал</b>   | <b>4,920,000.00</b>   | <b>5,244,000.00</b>     |
| 210702 | Дотоод албан томилолт   | 4,920,000.00          | 5,244,000.00            |
| 2108   | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>   | <b>40,919,300.00</b>  | <b>55,648,100.00</b>    |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж  | 38,593,000.00         | 52,184,900.00           |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох  | 360,000.00            | 360,000.00              |
| 210803 | Даатгалын үйлчилгээ   | 1,585,000.00          | 1,566,100.00            |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар  | 181,800.00            | 187,600.00              |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо   | 44,000.00             | 44,000.00               |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ   | 0.00                  | 1,150,000.00            |
| 210807 | Газрын төлбөр   | 155,500.00            | 155,500.00              |

|        |   |                       |                       |
|--------|---|-----------------------|-----------------------|
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх              | 0.00                  | 0.00                  |
| 2109   | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>              | <b>69,979,255.46</b>  | <b>115,099,388.07</b> |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал                     | 1,654,200.00          | 21,097,120.00         |
| 210902 | Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх                    | 13,772,223.50         | 9,183,975.00          |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал           | 54,552,831.96         | 84,818,293.07         |
| 213    | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                             | <b>22,736,709.17</b>  | <b>110,842,950.61</b> |
| 2131   | <b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>              | <b>1,323,000.00</b>   | <b>0.00</b>           |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг                     | 1,323,000.00          | 0.00                  |
| 2132   | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                       | <b>14,283,725.00</b>  | <b>48,333,798.00</b>  |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал      | 0.00                  | 840,000.00            |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 10,683,725.00         | 45,233,798.00         |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал             | 3,600,000.00          | 2,260,000.00          |
| 2133   | <b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>  | <b>7,129,984.17</b>   | <b>62,509,152.61</b>  |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг                               | 7,129,984.17          | 62,509,152.61         |
| 3      | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>           | <b>142,458,353.58</b> | <b>-58,151,017.50</b> |
| 225    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>              | <b>17.64</b>          | <b>0.00</b>           |
| 225001 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз                | 17.64                 | 0.00                  |
| 4      | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>     | <b>-17.64</b>         | <b>0.00</b>           |
| 5      | <b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>                      | <b>142,458,335.94</b> | <b>-58,151,017.50</b> |

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код  | Үзүүлэлт   | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|------|--|---------------------------------|-----------------------|----------------------|--|
| 4-01 | 2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл             | 351,819,591.65                  | 161,512,362.38        | -27,346,065.64       | 485,985,888.39                         |
| 4-02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт       | 0.00                            | 0.00                  | 0.00                 | 0.00                                   |
| 4-03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                       | 351,819,591.65                  | 161,512,362.38        | -27,346,065.64       | 485,985,888.39                         |
| 4-04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00                            | 0.00                  | 0.00                 | 0.00                                   |
| 4-05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт                  | 0.00                            | 0.00                  | 0.00                 | 0.00                                   |
| 4-06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз    | 0.00                            | 0.00                  | 0.00                 | 0.00                                   |
| 4-07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү               | 0.00                            | 0.00                  | 0.00                 | 0.00                                   |
| 4-08 | Тайлант үеийн үр дүн                             | 0.00                            | 0.00                  | 142,458,335.94       | 142,458,335.94                         |
| 4-01 | 2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл             | 351,819,591.65                  | 161,512,362.38        | 115,112,270.30       | 628,444,224.33                         |
| 4-02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт       | 0.00                            | 0.00                  | 0.00                 | 0.00                                   |
| 4-03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                       | 351,819,591.65                  | 161,512,362.38        | 115,112,270.30       | 628,444,224.33                         |
| 4-04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00                            | 0.00                  | 0.00                 | 0.00                                   |
| 4-05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт                  | 0.00                            | 0.00                  | 0.00                 | 0.00                                   |
| 4-06 | Орлогын тайланд хүлээн                           | 0.00                            | 0.00                  | 0.00                 | 0.00                                   |

|      |                                      |                |                |                |                |
|------|--------------------------------------|----------------|----------------|----------------|----------------|
|      | зөвшөөрөөгүй олз, гарз               |                |                |                |                |
| 4-07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү   | 0.00           | 0.00           | 0.00           | 0.00           |
| 4-08 | Тайлант үеийн үр дүн                 | 0.00           | 0.00           | -58,151,017.50 | -58,151,017.50 |
| 4-01 | 2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 351,819,591.65 | 161,512,362.38 | 56,961,252.80  | 570,293,206.83 |

#### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт   | Өмнөх оны дүн  | Тайлант оны дүн |
|------------|--|----------------|-----------------|
| 0          | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ   | 0.00           | 0.00            |
| 1          | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>  | 828,873,950.00 | 978,524,625.00  |
| 12         | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>   | 1,663,500.00   | 27,250.00       |
| 120        | <b>Нийтлэг татварын бус орлого</b>   | 1,663,500.00   | 27,250.00       |
| 120004     | Төсөв байгууллагын өөрийн орлого   | 1,663,500.00   | 0.00            |
| 1200042    | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих  | 1,663,500.00   | 0.00            |
| 120009     | Бусад орлого   | 0.00           | 27,250.00       |
| 13         | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>   | 827,210,450.00 | 978,497,375.00  |
| 1310       | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>   | 811,885,725.00 | 957,497,400.00  |
| 131001     | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт  | 811,885,725.00 | 957,497,400.00  |
| 1311       | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>   | 1,860,000.00   | 0.00            |
| 131104     | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,500,000.00   | 0.00            |
| 131105     | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                               | 360,000.00     | 0.00            |
| 1320       | <b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>  | 13,464,725.00  | 20,999,975.00   |
| 132001     | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/  | 13,464,725.00  | 20,999,975.00   |
| 2          | <b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>   | 828,873,950.00 | 974,426,725.00  |
| 21         | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | 828,873,950.00 | 974,426,725.00  |
| 210        | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>   | 805,872,640.83 | 863,583,774.39  |
| 2101       | <b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>  | 606,964,028.95 | 656,165,057.67  |
| 210101     | Үндсэн цалин   | 422,179,950.53 | 371,392,983.67  |
| 210102     | Нэмэгдэл   | 102,273,479.77 | 159,711,386.37  |
| 210103     | Унаа хоолны Хөнгөлөлт  | 24,796,795.65  | 52,943,021.00   |
| 210104     | Урамшуулал   | 57,713,803.00  | 72,117,666.63   |
| 2102       | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>  | 88,349,818.88  | 87,487,552.72   |
| 210201     | Тэтгэврийн даатгал   | 61,342,316.85  | 61,539,862.41   |
| 210202     | Тэтгэмжийн даатгал   | 6,875,727.18   | 6,832,925.87    |
| 210203     | ҮОМШӨ-ний даатгал  | 5,429,997.56   | 5,230,679.07    |
| 210204     | Ажилгүйдлийн даатгал   | 1,336,608.33   | 1,264,896.92    |
| 210205     | Эрүүл мэндийн даатгал  | 13,365,168.96  | 12,619,188.45   |
| 2103       | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>   | 12,520,000.00  | 12,327,200.00   |
| 210301     | Гэрэл, цахилгаан   | 4,299,999.60   | 4,652,600.00    |
| 210302     | Түлш, халаалт  | 5,169,787.40   | 5,248,000.00    |
| 210303     | Цэвэр, бохир ус  | 3,050,213.00   | 2,426,600.00    |
| 2104       | <b>Хангамж, бараа материалын зардал</b>  | 22,710,500.00  | 28,320,389.00   |
| 210401     | Бичиг хэрэг  | 4,197,900.00   | 6,560,000.00    |
| 210402     | Тээвэр, шатахуун   | 4,833,000.00   | 7,672,000.00    |
| 210403     | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр   | 5,372,900.00   | 5,567,000.00    |
| 210404     | Ном, хэвлэл  | 447,600.00     | 423,439.00      |
| 210405     | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал  | 1,005,100.00   | 1,348,200.00    |
| 210406     | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс  | 6,854,000.00   | 6,749,750.00    |
| 2106       | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>   | 3,349,800.00   | 8,801,500.00    |

|        |  |               |                |
|--------|--|---------------|----------------|
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл  | 0.00          | 3,501,500.00   |
| 210604 | Урсгал засвар  | 3,349,800.00  | 5,300,000.00   |
| 2107   | <b>Томилолт, зочны зардал</b>  | 4,920,000.00  | 5,244,000.00   |
| 210702 | Дотоод албан томилолт  | 4,920,000.00  | 5,244,000.00   |
| 2108   | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | 42,582,800.00 | 55,898,100.00  |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 38,593,000.00 | 52,184,900.00  |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                             | 360,000.00    | 360,000.00     |
| 210803 | Даатгалын үйлчилгээ  | 1,585,000.00  | 1,566,100.00   |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар   | 225,800.00    | 187,600.00     |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо  | 0.00          | 44,000.00      |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                      | 0.00          | 1,400,000.00   |
| 210807 | Газрын төлбөр  | 155,500.00    | 155,500.00     |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх                               | 1,663,500.00  | 0.00           |
| 2109   | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | 24,475,693.00 | 9,339,975.00   |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 8,960,000.00  | 0.00           |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                    | 15,515,693.00 | 9,339,975.00   |
| 213    | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | 23,001,309.17 | 110,842,950.61 |
| 2131   | <b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>                               | 1,587,600.00  | 0.00           |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг                                      | 1,587,600.00  | 0.00           |
| 2132   | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>  | 14,283,725.00 | 48,333,798.00  |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал                       | 0.00          | 840,000.00     |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж                  | 10,683,725.00 | 45,233,798.00  |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                              | 3,600,000.00  | 2,260,000.00   |
| 2133   | <b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>                   | 7,129,984.17  | 62,509,152.61  |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг  | 7,129,984.17  | 62,509,152.61  |
| 3      | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)                     | 0.00          | 4,097,900.00   |
| 5      | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)                            | 0.00          | 4,097,900.00   |
| 22     | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>  | 0.00          | 4,097,900.00   |
| 2200   | Дотоод эх үүсвэрээр  | 0.00          | 4,097,900.00   |
| 223001 | Бусад хөрөнгө  | 0.00          | 4,097,900.00   |
| 6      | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)  | 0.00          | -4,097,900.00  |
| 9      | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>              | 0.00          | 0.00           |
| 10     | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>             | 0.00          | 0.00           |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Эдийн засгийн ангилал                                 | Төлөвлөгөө            | Төсвийн гүйцэтгэл     |
|------------|---|-----------------------|-----------------------|
|            | <b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>              | <b>957,497,400.00</b> | <b>895,015,497.39</b> |
|            | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                  | <b>957,497,400.00</b> | <b>895,015,497.39</b> |
|            | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                | <b>910,163,500.00</b> | <b>847,681,699.39</b> |
|            | <b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>             | <b>710,249,900.00</b> | <b>656,165,057.67</b> |
| 210101     | Үндсэн цалин  | 410,930,700.00        | 371,392,983.67        |
| 210102     | Нэмэгдэл  | 143,492,300.00        | 159,711,386.37        |
| 210103     | Унаа хоолны Хөнгөлөлт                                 | 62,436,000.00         | 52,943,021.00         |
| 210104     | Урамшуулал  | 93,390,900.00         | 72,117,666.63         |
|            | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b> | <b>95,873,700.00</b>  | <b>87,487,552.72</b>  |
| 210201     | Тэтгэврийн даатгал                                    | 67,463,700.00         | 61,539,862.41         |
| 210202     | Тэтгэмжийн даатгал                                    | 7,102,500.00          | 6,832,925.87          |

|        |  |                       |                       |
|--------|--|-----------------------|-----------------------|
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал  | 5,682,000.00          | 5,230,679.07          |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал   | 1,420,500.00          | 1,264,896.92          |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал  | 14,205,000.00         | 12,619,188.45         |
|        | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                     | <b>12,327,200.00</b>  | <b>12,327,200.00</b>  |
| 210301 | Гэрэл, цахилгаан   | 4,652,600.00          | 4,652,600.00          |
| 210302 | Түлш, халаалт  | 5,248,000.00          | 5,248,000.00          |
| 210303 | Цэвэр, бохир ус  | 2,426,600.00          | 2,426,600.00          |
|        | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                              | <b>26,330,600.00</b>  | <b>26,320,389.00</b>  |
| 210401 | Бичиг хэрэг  | 6,560,000.00          | 6,560,000.00          |
| 210402 | Тээвэр, шатахуун   | 5,672,000.00          | 5,672,000.00          |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                                   | 5,567,000.00          | 5,567,000.00          |
| 210404 | Ном, хэвлэл  | 433,400.00            | 423,439.00            |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал            | 1,348,200.00          | 1,348,200.00          |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                          | 6,750,000.00          | 6,749,750.00          |
|        | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                             | <b>9,900,000.00</b>   | <b>9,899,400.00</b>   |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл  | 4,600,000.00          | 4,599,400.00          |
| 210604 | Урсгал засвар  | 5,300,000.00          | 5,300,000.00          |
|        | <b>Томилолт, зочны зардал</b>  | <b>5,244,000.00</b>   | <b>5,244,000.00</b>   |
| 210702 | Дотоод албан томилолт  | 5,244,000.00          | 5,244,000.00          |
|        | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | <b>49,418,100.00</b>  | <b>49,418,100.00</b>  |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 45,704,900.00         | 45,704,900.00         |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                             | 360,000.00            | 360,000.00            |
| 210803 | Даатгалын үйлчилгээ  | 1,566,100.00          | 1,566,100.00          |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар   | 187,600.00            | 187,600.00            |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо  | 44,000.00             | 44,000.00             |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                      | 1,400,000.00          | 1,400,000.00          |
| 210807 | Газрын төлбөр  | 155,500.00            | 155,500.00            |
|        | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | <b>820,000.00</b>     | <b>820,000.00</b>     |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага   | 820,000.00            | 820,000.00            |
|        | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | <b>47,333,900.00</b>  | <b>47,333,798.00</b>  |
|        | Засгийн газрын дотоод шилжүүлэг                                      | 0.00                  | 0.00                  |
|        | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>  | <b>47,333,900.00</b>  | <b>47,333,798.00</b>  |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал                       | 840,000.00            | 840,000.00            |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж                  | 45,233,900.00         | 45,233,798.00         |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                              | 1,260,000.00          | 1,260,000.00          |
|        | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                | <b>957,497,400.00</b> | <b>895,042,747.39</b> |
|        | <b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                                       | <b>957,497,400.00</b> | <b>895,015,497.39</b> |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих  | 957,497,400.00        | 895,015,497.39        |
|        | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл                     | 0.00                  | 0.00                  |
|        | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл                    | 0.00                  | 0.00                  |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт   | Гүйцэтгэл            |
|------------|--|----------------------|
| I          | <b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                             | <b>20,999,975.00</b> |
| 21         | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>20,999,975.00</b> |
| 210        | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                               | <b>19,999,975.00</b> |
| 2104       | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                              | <b>2,000,000.00</b>  |
| 210402     | Тээвэр, шатахуун   | 2,000,000.00         |
| 2106       | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                             | <b>3,000,000.00</b>  |
| 210601     | Багаж, техник, хэрэгсэл  | 3,000,000.00         |
| 2108       | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | <b>6,480,000.00</b>  |
| 210801     | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,480,000.00         |

|             |   |                      |
|-------------|---|----------------------|
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                              | <b>8,519,975.00</b>  |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                   | 8,519,975.00         |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>   | <b>1,000,000.00</b>  |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                                       | <b>1,000,000.00</b>  |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                             | 1,000,000.00         |
| <b>II</b>   | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                               | <b>20,999,975.00</b> |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>                                  | <b>20,999,975.00</b> |
| 131101      | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 20,999,975.00        |
|             | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл                    | 0.00                 |
|             | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл                   | 0.00                 |

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дорнод аймгийн Татварын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах, аудитор Ч.Удвалноров нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Дорнод аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 1/21 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл нь татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт сурталчилгаа явуулах, татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн орлогыг бүрдүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дорнод аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 870.8 сая төгрөгөөс 75 хувиар буюу 10.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 7.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Бараа материалын дансны үлдэгдэл 31.4 сая төгрөг байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 789.1 сая төгрөг болж өмнөх оноос 35.1 сая төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн данс нь төсвийн хөрөнгийн худалдан авалтаар 4.1 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, үнэ төлбөргүй шилжиж ирсэн 31.0 сая төгрөгийн машин тоног төхөөрөмжөөр нэмэгдсэн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 18.2 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд үнэ төлбөргүй хүлээн авсан орлого өмнөх оноос 133.1 сая төгрөгөөр буурч, улсын төсвийн санхүүжилт 145.6 сая төгрөгөөр, дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан хөрөнгө 5.7 сая төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 223.9 сая төгрөгөөр өссөн нь бараа, ажил үйлчилгээний зардал 135.8 сая төгрөгөөр, урсгал шилжүүлэг 88.1 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 957.5 сая төгрөгөөр, нийт зарлагыг 957.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 957.5 сая төгрөгийн төсөв баталснаас 957.5 сая төгрөгийг улсын төсвөөс бүрэн баталсан байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 957.5 сая төгрөгийн санхүүжилт авч 895.0 сая төгрөг буюу 93.5 хувийг урсгал үйл ажиллагаанд зарцуулж, 62.5 сая төгрөг буюу 6.5 хувийг буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн дансаар орон нутгийн төсвөөс 20.9 сая төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна. Бараа, ажил үйлчилгээний зардалд 19.9 сая төгрөг, урсгал шилжүүлэг 1.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

## **3.8 Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ, үйл явдал гараагүй байна.

## **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дорнод аймгийн Татварын хэлтэс нь 2021 онд нийт 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 148 мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлж, 1 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3.1 сая төгрөгийн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар гэрээний биелэлтийн хэрэгжилтийг хянаж үзэх.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 5.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 5.1 сая төгрөгийн алдааг залруулан, 1 албан шаардлага өгч, 1 зөвлөмж өгсөн.

### **4.1 Залруулсан алдаа**

"Гэрэлт өндөрлөг" ХХК-тай байгуулсан гэрээний дагуу хийгдээгүй ажлын 5.1 сая төгрөгийг авлагаар тусгуулж залруулга хийлгэв.

### **4.2 Төлбөрийн акт**

Тайлант хугацаанд төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

### **4.3 Албан шаардлага**

Байгууллагаас авах 5.1 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх." гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал**

- 1.1. Илрүүлэлт: Тайлант онд Шилэн дансны сайтад 1 мэдээлэл хуулийн хугацааг хоцроон мэдээлсэн.
- 1.2. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэсэн заасны дагуу мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 5 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн |     | Үүнээс    |     |               |     |                 |     |         |     |
|-----|-------------------------------------|----------------------|-----|-----------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|
|     |                                     |                      |     | Залруулга |     | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |     |
|     |                                     | Тоо                  | Дүн | Тоо       | Дүн | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо     | Дүн |
| 1   | Дорнод аймгийн Татварын хэлтэс      | 3                    | 5.1 | 1         | 5.1 | -             | -   | 1               | -   | 1       | -   |